



ЧИМЭГЭ СОНУР

ANDROID ГАР УТСАН ДЭЭР АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА

MON 48076 тоот “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах нь” төслийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкны санхүүгийн дэмжлэгтэй Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны захиалгаар Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан монгол хэлээр дэлгэц уншигч “Чимэгэ Сонур” системийг хүн бүр үнэ төлбөргүй, бүх үйлдлийн системд ашиглах боломжтойгоор “Болорсофт” ХХК, “Чимэгэ Системс” ХХК хамтран бүтээв.

1. ЧИМЭГЭ СОНУРЫГ ANDROID ГАР УТАС БА ТАБЛЕТ ДЭЭР СУУЛГАХ

Google-ийн албан ёсны эрхтэй гар утаснуудад дэлгэц уншигч программ болох Android Accessibility Suite программ үйлдвэрээсээ суусан байх бөгөөд уг тохиолдолд Чимэгэ Сонур аппыг шууд суулган Монгол бичвэрийг унших боломжтой болох юм. Хэрэв Android Accessibility Suite суугаагүй бол утасны төрлөөс шалтгаалан Android Accessibility Suite суулгах арга нь өөр өөр байна.

Та гар утсан дээрээ Android Accessibility Suite суусан эсэхийг дараах аргаар шалгаж болно: Settings апп руу ороод Accessibility цэс дотор TalkBack гэсэн сонголт байгаа эсэхийг шалгана. Хэрэв TalkBack гэсэн сонголт байхгүй бол дараах холбоосоор орж суулгах боломжтой: <https://play.google.com/store/apps/details?id=com.google.android.marvin.talkback>

Анхааруулга: Android Accessibility Suite буюу talkback-ыг идэвхжүүлсэн тохиолдолд таны гар утасны дэлгэц ярьдаг программын горимд шилжих тул анх удаа Android хэрэглэж байгаа бол идэвхжүүлэхийн өмнө Android системийн ярьдаг программын удирдах аргатай танилцана уу: <https://support.google.com/accessibility/android/answer/6151827?hl=en>

1.1. PlayStore-оос татаж суулгах

Утасныхаа PlayStore-ыг нээж дэлгэцийн дээд талд байрлах хайлтын хэсэгт **chimege sonur**, эсвэл **Чимэгэ Сонур** гэсэн түлхүүр үгийг оруулж хайх буюу search товч дээр дарна. Гарч ирсэн илэрцээс /Чимэгэ Сонур Chimege systems/ гэсний баруун талд байрлах install товчийг дарж утсандаа суулгана. Хэрэв install товч харагдахгүй бол /Чимэгэ Сонур Chimege systems/ дээр дарахад баруун дээд талд байрлах 3 цэгийн доор install товч харагдана. Install товчийг дарж Чимэгэ Сонур апп-ыг утсандаа суулгана.

1.2. Чимэгэ Сонур сайтаас татаж суулгах

Гар утасны хөтчөөс <https://sonur.chimege.com/> сайт руу ороод татах цэс дээр даран Android/TalkBack хэсэгт байрлах PlayStore-ын холбоос дээр дарахад PlayStore нээгдэх ба Install товч дээр дарж Чимэгэ Сонур апп-ыг утсандаа суулгана.

1.3. PlayStore ашиглахгүйгээр суулгах

Чимэгэ Сонур апп-ын хэмжээ 200 гаран МВ тул хэрэв таны гар утасны дата хязгаартай бол компьютер ашиглан <https://sonur.chimege.com/> сайтын Татах цэс рүү ороод Android/TalkBack хэсгээс Шууд татах холбоос дээр дарж **chimege_sonur_vxx.apk** файлыг татаж, утсан дээрээ суулгаж болно. Мөн PlayStore ашиглах боломжгүй гар утас, жишээлбэл huawei үйлдвэрийн гар утастай бол утасныхаа веб хөтчийг ашиглан адил үйлдлээр APK файлыг татаж суулгах боломжтой. APK файлыг суулгахад утасны тохиргооноос шалтгаалан install товч харагдахгүй байж болно. Хэрэв install товч харагдахгүй settings, cancel товч гарч ирвэл settings дээр дарж unknown sources хэсгээс install from this source гэснийг зөвлөөд буцах товч дээр дарахад install товч харагдах болно. APK файл суулгах тохиргоо нь тухайн утас болон үйлдлийн системийн хувилбараас шалтгаалан өөр өөр тул зарим тохиолдолд settings->developer options цэсээс install from unknown source сонголтыг зөвлөсний дараа суулгах тохиолдол гарж болзошгүй юм.

2. ЧИМЭГЭ СОНУР АПП-ЫН ТОХИРГОО

Хэрэв Чимэгэ Сонур апп-ыг амжилттай суулгасан бол утас болон таблетын программын цэс дотор Чимэгэ Сонур нэмэгдсэн байх бөгөөд программыг нээж дараах тохиргоонуудыг өөрийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулах боломжтой.

2.1. Хоолойны тохиргоо

Чимэгэ Сонур аппын хоолойны тохиргоо нь ихэсгэж багасгах зориулалттай гулсуулагч буюу slider тохиргоо, тэмдэглэж идэвхжүүлэх буюу check box тохиргоо, эсвэл өгөгдсөн хувилбаруудаас өөрт тохирсон сонголтыг сонгож тохируулдаг байхаар хөгжүүлсэн. Гулсуулагч буюу slider нь Android Accessibility Suite talkback-ын хувилбараас шалтгаалан дараах 2 янзаар тохируулах боломжтой. Хэрэв Android Accessibility Suite talkback-ын хувилбар нь 13.0 ба түүнээс дээш бол slider буюу тоо бүхий гулсуулагчийг сонгож, нэг хуруугаар дээш эсвэл доош хурдан шувтарч тохируулна. Хэрэв Android Accessibility Suite talkback-ын хувилбар нь 13-аас доош бол slider буюу гулсуулагчийг сонгож утасны volume товч буюу дууг чангалж суллах товчийг ашиглан тохируулах боломжтой.

Хурд %100 → Ярианы хурдыг тохируулна.

Өнгө %100 → Дууны өнгийг тохируулна.

Чанга сул %100 → ярианы чанга сулыг тохируулна.

Хоолойны сонголт: **Эмэгтэй 3, эрэгтэй 3** хоолой байх бөгөөд хэрэв утасны хүчин чадал бага бол эмэгтэй tiny, эмэгтэй small зэргээс өөрт тохирсныг сонгож хэрэглэх боломжтой.

Google хоолойны сонголт: Одоогоор Монголоос бусад хэлийг Google хоолойгоор уншуулах боломжтой бөгөөд цаашдаа бусад engine холбогдоно. Одоогоор google-н 10 төрлийн хоолойноос сонгох боломжтой.

Ачаалах сегментийн хэмжээ 100: → Хэрэв таны ашиглах гар утасны хүчин чадал өндөр бол уг тоог багасгах замаар дэлгэц уншигч ярьж эхлэх хурдыг нэмэгдүүлэх боломжтой. Хэрэв утасны хүчин

чадал бага бол дэлгэц уншигч программ гацах тул уг тохиргооны хэмжээг нэмснээр гацалт бага болно.

Сегментийн давхцал 20: Энэ тоо өндөр байх тусам үг хоорондын залгаас бага болно.

Текст бүлэглэх хэмжээ 50: Санах ойд ачаалах текстийн хэмжээ бөгөөд утасны үзүүлэлтээс шалтгаалан тохируулна.

2.2. Текстийн тохиргоо

Эможи Унших: Уг тохиргоог идэвхжүүлснээр инээмсэглэсэн царай гэх мэт эможиг Монголоор уншина.

Товчлол унших: Уг тохиргоог идэвхжүүлснээр түгээмэл товчилсон үгийг уншина. Жишээлбэл УИХ (Улсын Их Хурал.)

Тэмдэгт унших тохиргоо: Уг тохиргоо хэсэгт бүх тэмдэгтийг уншуулах, түгээмэл тэмдэгтийг уншуулах, заасан тэмдэгтийг уншуулах, Зааснаас бусад тэмдэгтийг уншуулах гэсэн сонголтуудыг тохируулах боломжтой.

Гадаад үг унших тохиргоо: Гадаад үгийг Монгол галигаар дуудах, эсвэл google engine ашиглан тухайн орны дуудлагаар уншуулах боломжтой.

Мөн тооны холбоосыг уншуулах, дэс дугаарыг уншуулах, тоог 2 эсвэл нэг нэгээр, эсвэл бүх тоог нэгтгэж уншуулах тохиргоог хийх боломжтой.

3. ЧИМЭГЭ ХООЛОЙГ ИДЭВХЖҮҮЛЭХ

Чимэгэ Сонурыг нээж баруун дээд талын 3 цэг буюу more options товчийг дарж, гарч ирсэн цэсээс General TTS Settings гэж сонгоод, preferred engine дотроос Чимэгэ Сонурыг сонгох. Эсвэл TalkBack global options цэсээс text to speech settings гэж сонгоод, preferred engine сонголтыг Чимэгэ Сонур болгон тохируулна.

Анхааруулга: Чимэгэ Сонурыг сонгоход уг программ таны нууц үг болон кредит картын мэдээллийг унших боломжтой гэсэн утга бүхий анхааруулга гарах бөгөөд энэ нь нэмэлтээр суулгасан бүх хоолойнууд дээр гардаг анхааруулга болно.

Уг сонголтыг зөвшөөрснөөр Чимэгэ хоолой ажиллаж эхлэх бөгөөд таны утас Монгол бичвэрийг унших боломжтой болно.

4. ЧИМЭГЭ СОНУР АПШЫГ УСТГАХ

Аюулгүй байдлын үүднээс Чимэгэ хоолойг устгахын өмнө өөр хоолой идэвхжүүлэхийг зөвлөө.

Чимэгэ хоолойг устгахдаа бусад программын адил applications дотроос uninstall гэж сонгож устгах, эсвэл Чимэгэ Сонур дээр хоёр товшиж хуруугаа салгалгүй 1 секунд орчим дарж хүлээснээр app info цэс гарч ирэх бөгөөд түүн дотроос uninstall сонголтыг сонгон устгах боломжтой.

5. ТУСЛАМЖ

Хэрэв танд программтай холбоотой гомдол, санал хүсэлт болон асууж лавлах зүйл байвал доорх мэдээллийн дагуу холбогдоно уу.

1. Б. Ангараг-Эрдэнэ

Утас: +976 88962476

Фейсбүүк хаяг: Angaragerdene Bayarbaatar

<https://www.facebook.com/b.angaragerdene>

2. Б. Зоригт

Утас: +976 99821616

Фейсбүүк хаяг: Zorigt Batjargal

<https://www.facebook.com/profile.php?id=100007383736073>

3. Э. Дэлгэрбаяр

Фейсбүүк хаяг: Delgerbayar Erdenesambuу

<https://www.facebook.com/Delgerbayar.neo>